



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/НЧБ

Зуунмод

Г Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд Г
газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, Сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 03 дугаар Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт тодотголыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын ЗДТГ-ын хүсэлтийн дагуу Баянхошуу /3-р/ багийн Сүмийн баруун талд байршилд Тоглоомын талбай зориулалтаар 6600м² газрыг Зуунмод сумын ЗДТГ (9058923)-т 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Засаг даргын тамгын газарт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1.Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2.Газрын кадастрын зураглалыг хийлгэж, Мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3.Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4.Эзэмшиж байгаа газрынхаа эргэн тойронд (50-аас доошгүй метрийн радиус)-ын доторхи хог хаягдлыг тогтмол цэвэрлэж, орчноо цэвэр ариун байлгах арга хэмжээ авах.

3.Газрын даамал (Г.Баярсайхан)-д дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1.Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах

3.2.Газрын төлбөрийг хугацаанд нь төсөвт оруулах

3.3.Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллах.

ЗАСАГ ДАРГА

Б.САРАНГЭРЭЛ

